




МОНГОЛ  
ШУУДАН



**“МОНГОЛ ШУУДАН” ХК  
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Жич: Өөрийн үнэлгээ

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### Нэг. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс томилогдсон эрх бүхий албан тушаалтан хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2-оос доoshгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Монголын Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

### Хоёр. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Өөрийн үнэлгээгээр авсан оноо	Хяналтын оноо	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100 %
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100 %
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100 %
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83 %
5	Эрсдэлийн удирдлага	8	7		88 %
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100 %
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100 %
8	Компанийн соёл	6	6		100 %
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100 %
Нэгдсэн дүн		72	70		97%

Компанийн засаглалын үнэлгээгээр 70 оноо буюу 97 хувиар үнэлэгдээж “Хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ.

## **Гурав. Үнэлгээний аргачлал**

3.1. Асуулга тус бүрийн хувьд хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

2025.06.20

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>						
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайллагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..						
<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>						
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна						
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>	
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 1-р хавсралтаар “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Тус журмаар ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн даргын чиг үүрэг, эрх үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан бөгөөд ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг компанийн веб сайтад нийтэд ил тод мэдээлэлдэг.	2	100%	
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 3-р хавсралтаар “Нэр дэвшүүлэх хорооны үйл журам”-ыг баталж, ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааны бодлогын талаар тусгасан.	2	100%	
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бурийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.</b>	Бүрэн хэрэгжсэн	Гишүүдийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ зэрэг мэдээллийг нэгтгэн цахим хуудсанд байршуулсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны тайланд мөн тусгахаар зорьж байна. <a href="https://mongolpost.mn:8088/wp-content/uploads/2025/04/НЕН-ийн-material.pdf">https://mongolpost.mn:8088/wp-content/uploads/2025/04/НЕН-ийн-material.pdf</a>	2	100%	
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 2-р хавсралтаар “Аудитын хорооны ажиллах журам”, 3-р хавсралтаар “Нэр дэвшүүлэх хорооны үйл журам”, 4-р хавсралтаар “Цалин, урамшууллын хорооны ажиллах журам”-ыг тус тус баталж хороодын гишүүнд тавигдах шаардлагыг тусгасан.	2	100%	

5	<b>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үргээ гүйцэтгэхдээ шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлээр “Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд зориулсан жилийн сургалтын хөтөлбөрийг баталсан бөгөөд шинээр томилогдсон З гишүүнд чиглүүлэх сургалтыг өгсөн.	2	100%
6	<b>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хулээнэ.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 1-р хавсралтаар “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг тусгаж, ажлын тайланг компанийн цахим хуудсанд байршуулав.	2	100%

ДҮН

**ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ****ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ**

7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4. “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу ТУЗ-ийн 9 гишүүнээс 3 хараат бус /Б.Ганбаатар, Ч.Амарбаатар, Д.Балдорж/ гишүүнтэй.	2	100%
8	<b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхуу тус хорооны хүсэлтээр оролцно.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 2-р хавсралтаар “Аудитын хорооны ажиллах журам”-ыг баталсан бөгөөд даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн байдал. Тус журмаар хорооны хурлын 4 дүгээр зүйлээр хорооны хурлын зохион байгуулалтыг зохицуулсан бөгөөд хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд аудиторын хүсэлтээр оролцох зохицуулалттай.	2	100%
9	<b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхуу хорооны хүсэлтээр оролцно.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 4-р хавсралтаар “Цалин, урамшууллын хорооны ажиллах журам”-ыг баталсан бөгөөд дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн байдал. Мөн хорооны хурлын зохион байгуулалтыг зохицуулсан бөгөөд хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд аудиторын хүсэлтээр оролцох зохицуулалттай.	2	100%
10	<b>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 3-р хавсралтаар “Нэр дэвшүүлэх хорооны үйл журам”-ыг баталсан бөгөөд нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байдал.	2	100%

11	<p><b>2.5. ТУЗ нь оорийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүрээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	<p>“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 2-р хавсралтаар “Аудитын хорооны ажиллах журам”, 3-р хавсралтаар “Нэр дэвшиүүлэх хорооны үйл журам”, 4-р хавсралтаар “Цалин, урамшууллын хорооны ажиллах журам”-ыг баталсан.  <a href="https://mongolpost.mn:8088/wp-content/uploads/2025/04/НЕН-iin-material.pdf">https://mongolpost.mn:8088/wp-content/uploads/2025/04/НЕН-iin-material.pdf</a></p>	2	100%
----	---	-----------------	--	---	------

### **ДҮН**

#### **ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

**ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана**

12	<p><b>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлagnalын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	<p>“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/12/27-ны өдрийн дугаар 24/24 тогтоолоор “Мэдээллийн ил тод байдал, тайлagnalын журам”-ыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.</p>	2	100%
13	<p><b>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хургэнэ.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	<p><a href="https://www.mongolpost.mn/corporate-governance/transparency">https://www.mongolpost.mn/corporate-governance/transparency</a></p>	2	100%
14	<p><b>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлagnal нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд ногоонж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хурсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	<p>Хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланг компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулдаг.</p>	2	100%

### **ДҮН**

#### **ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

**ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана**

15	<p><b>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрээ саадгүй гүйцэтгэх нохцол боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	<p>“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/10/24-ний өдрийн дугаар 24/15 тогтоолын 2-р хавсралтаар “Аудитын хорооны ажиллах журам”-ыг баталсан. Журмын 2.1 дэх заалтаар аудитын хороон нь хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрээ саадгүй гүйцэтгэх нохцөл боломжоор хангах чиг үүргийг тусгайлан зааж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>	2	100%
----	---	-----------------	---	---	------

16	<p><b>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжист хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</b></p>	Хэрэгжиж байгаа	Хөндлөнгийн аудиторын дүгнэлтийг аудитын хорооны дарга ХЭХ-д танилцуулан ажиллаж байгаа бөгөөд цаашид ТУЗ нь дэргэдээ дотоод аудитортай байхаар зорьж 2024 оны 12 сард бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулан, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос 2025 онд сонгон шалгаруулалт зарлахаар тогтсон.	1	50%
17	<p><b>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлий.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	Компани ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор сонгон шалгаруул зарыг цахим хуудсаараа нээлтгэй мэдээлэлсэн бөгөөд 2024 оны үйл ажиллагааны тайланд дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлж буй хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаар тусгаж цахим хуудсанд байршуулан ажилладаг.	2	100%
ДҮН				5	83%

#### **ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина**

18	<p><b>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2023/08/25-ны өдрийн дугаар 23/13 тогтоолын 4-р хавсралтаар “Эрсдэлийн удирдлагын заавар”-ыг баталж, үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавьдаг.	2	100%
19	<p><b>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнүүтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.</b></p>	Хэрэгжүүлэхээр зорьж байна	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь эрсдэлийн удирдлагын хорооны чиг үүргийг хэрэгжүүлж болохоор засан бөгөөд хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгахаар бэлтгэж байна.	1	50%
20	<p><b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг унэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдааж буйгаа тайлбарлана.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	Байгаль орчин, нийгэм, засаглалын тайланг Монголын хөрөнгийн биржийн сайтад байршуулсан.	2	100%
21	<p><b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b></p>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2023/08/25-ны өдрийн дугаар 23/13 тогтоолын 7-р хавсралтаар “Комплайнсын хяналтын заавар”-ыг баталж, хэрэгжилт, хараат бус байдалд ТУЗ хяналт тавин ажилладаг.	2	100%
ДҮН				7	88%

## ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

**Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна**

22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцээс батална.</b>	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2025/04/25-ны өдрийн “Монгол шуудан” ХК-ийн ээлжит хурлын ХЭ-25/02 тогтоолоор ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг баталж, компанийн цахим хуудсанд байршуулсан.	2	100%
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>	Бүрэн хэрэгжсэн	Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2023/08/25-ны өдрийн дугаар 23/13 тогтоолын 3-р хавсралтаар “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг баталж, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан.	2	100%
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын хэмжээг нийтэд ил тод мэдээлэлдэг бөгөөд цаашид үйл ажиллагааны тайланд гүйцэтгэлийн шалгуур узүүлэлтийг тусгахаар зорьж байна.	2	100%
<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>100%</b>

## ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлийн**

25	<b>7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлийн.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн хагас жил, улирлын тайланг тогтмол компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулдаг.	2	100%
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</b>	Бүрэн хэрэгжсэн	Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан ололт, амжилт, мөн бизнесийн хүрээнд хамтарч ажиллахдаа баримталсан бодлого зэргийг тусгасан.	2	100%
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>	Бүрэн хэрэгжсэн	<a href="http://www.mongolpost.mn/">http://www.mongolpost.mn/</a> Компанийн цахим хуудсыг тогтмол ажиллуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилладаг.	2	100%
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын толовлогдоотэй байна.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар ажилчдын санал, хүсэлтийг шийдвэрлэх, нийгмийн асуудал буюу тэтгэвэр, тэтгэмж, мэргэжил дээшлүүлэх, хөгжүүлэх зэргээр сургалтын журам зэрэг дотоод хэм хэмжээг мөрдөн ажилладаг.	2	100%
<b>ДҮН</b>				<b>8</b>	<b>100%</b>

## НАЙМ. КОМПАНИЙН СӨЁЛ

**ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлжс, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2023/08/25-ны өдрийн дугаар 23/13 тогтоолын 2-р хавсралтаар “Ёс зүйн дүрэм”-ийг баталж, компанийн цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажилладаг.	2	100%
30	<b>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2023/08/25-ны өдрийн дугаар 23/13 тогтоолын 7-р хавсралтаар “Комплайнсын хяналтын заавар”-т “шүгэл үлээгч”-ийн тогтолцоог тусгасан.	2	100%
31	<b>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэрээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив оргох /оргохгүй байх/ талаар зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Ёс зүйн дүрэм”-д тусгасан.	2	100%

ДҮН

6

100%

**ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ****Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

32	<b>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжсэн	Цахим хуудсанд жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг тусган жил бүр мэдээлэлдэг.	2	100%
33	<b>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбортэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжсэн	Цахим хуудсыг тогтмол ажиллуулж байгаа бөгөөд оролцогч талуудаас холбогдох санал, хүсэлтийг хүлээн авч байна.	2	100%
34	<b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал огх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцолийг бүрдүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал огх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцолийг бүрдүүлж, хурлын тов, мэдээлэл зэргийг олон нийтэд нээлттэй зарлан мэдээлэлдэг.	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, омчлолийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал огх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b>	Бүрэн хэрэгжсэн	Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу ханган ажилладаг.	2	100%
36	<b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдохөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b>	Бүрэн хэрэгжсэн	“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024/12/27-ны өдрийн дугаар 24/23 тогтоолоор “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ыг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	2	100%

ДҮН

10

100%

**НЭГДСЭН ДҮН**

70

97%